



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 19 өдөр

Дугаар А/84

Хажуу шинэ үс

Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалт, 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Малын эрүүл мэндийн тухай хуулийн 18 дугаар зүйл 18.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Тус сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэр "Хар даравгай" хэмээх газарт нутаглах малчны суурьт мал, амьтны гоц халдварт Мязлан өвчний сэжигтэй шинж тэмдэг илэрсэнтэй холбогдуулан нийт малчид, иргэдэд урьдчилан сэргийлж анхааруулан голомтын бүсэд 2022 оны 09 дүгээр сарын 19-ний өдрөөс эхлэн 14 хоног хязгаарлалтын дэглэм тогтоосугай.

2. Мязлан өвчний шинж тэмдэг илэрсэн голомтын ойролцоо хааш хаашаа 5 км газарт хязгаарлалтын дэглэм тогтоон урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллахыг багийн засаг дарга (Г.Батчулуун)-д, малд үзлэг хийн ариутгал халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулахыг мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч (А.Бямбадорж), Угтаал чандмань хоршооны малын их эмч (Д.Амгалан) нарт тус тус даалгасугай.

3. Хүн малын шилжилт хөдөлгөөн, харуул хяналтын постыг 24 цагаар ажиллуулан, хүн малын ариутгал халдваргүйжүүлэлтэд хяналт тавьж, ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Сарангэрэл), хэсгийн цагдаа (Б.Наранбаатар), Эрүүл мэндийн төвийн эрхлэгч (Г.Энхдэлгэр) нарт тус тус даалгасугай

ЗАСАГ ДАРГА



Ө.МӨНХ-АМГАЛАН

48920178